

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ  
(2024 оны хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтээр)

2024 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

№	ХБТББ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэг-жих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн			Хэрэгжилт	Хувь
								Зорилтот түвшин, үр дүн	Төсөв (сая. төг)	Төсвийн гүйцэтгэл (сая. төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
БҮЛЭГ: ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО												
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ												
Зорилго: 3.4. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.												
Зорилт 3.4.1. Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.												
157	НЗДҮАХ 3.4.1.1.	Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг нэмэгдүүлнэ	2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	175.0	Жуулчны мэдээллийн 4 төвөөс 4,000 хүн мэдээлэл авсан.	Мэдээллийн төвөөр 6.000 хүн мэдээлэл авсан байна.	292.0	290.0	Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилтын хүрээнд үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг Жанжин Д.Сүхбаатарын талбайд шинээр байгуулж 2024 оны 10 дугаар сараас үйл ажиллагаагаа эхлүүлнэ. Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг 8 байршилд буюу Нийслэлийн Засаг захиргааны IV байр, “Төв шуудан”, жанжин Д.Сүхбаатарын талбай, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах	100

										Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төвүүд болон “Тэрэлж Монгол олле”, “Хонхор тосгон Монгол олле”, “Сөүлийн гудамж Монгол олле” төвүүдийг тогтмол болон улирлын чанартай ажиллуулан 16,180 хүнд, зохион байгуулсан үзэсгэлэн, эвент арга хэмжээнүүдийн үеэр жуулчны мэдээлэл сурталчилгааны цэгийг ажиллуулж 40,580 хүнд буюу нийт 56,760 гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.		
158	НЗДҮАХ 3.4.1.2.	Улаанбаатар хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлж, соёл, аялал жуулчлалын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, шинэ аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлнэ	2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	785.0	Аялал жуулчлалын чиглэлээр 10 үйл ажиллагаа зохион байгуулсан.	Аялал жуулчлалын чиглэлээр 15 үйл ажиллагаа зохион байгуулж, 70.000 хүн оролцсон байна.	890.7	866.7	“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадам, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Франц соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Талын салхи” олон улсын мото наадам, “Плэйтайм” олон улсын хөгжмийн наадам, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фүүд	100

											фестиваль”, “Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль”, “Японы соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Гранд тур” зэрэг аялал жуулчлалын 15 арга хэмжээг зохион байгуулж нийт гадаад, дотоодын 352,050 хүн үзэж сонирхсон.	
			2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	135.0	Улаанбаатар брэндийн 3 шинэ бүтээгдэхүүн бий болгож, 3,500 бараа бүтээгдэхүүнийг худалдаанд гаргасан.	Улаанбаатар брэнд төсөл, арга хэмжээг үргэлжлүүлсэн байна.	-	-	1.“Visit Ulaanbaatar” логот Улаанбаатар хотын сэтгүүл, хөтөч ном, нийслэл хотын газрын зураг зэрэг 3 төрлийн сурталчилгааны материал, 2 төрлийн бүтээгдэхүүн болон эвент арга хэмжээнүүдийн танилцуулга, контентуудад байршуулан олон нийтэд сурталчилан ажиллав. 2.Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг нэг дороос хэрэгцээт мэдээ мэдээлэлээр хангах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах зорилгоор “Visit Ulaanbaatar” гар утасны аппликейшны хөгжүүлэлтийг хийж Улаанбаатар хотын зорин очих газрууд, жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд, үзвэр, үйлчилгээний газруудын мэдээлэл, хаяг байршил болон эвент арга хэмжээ зэрэг 5 каталогийн нийт 90 гаруй мэдээ, мэдээллийг байршуулж монгол, англи хэл дээр мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.	100
159	НЗДҮАХ 3.4.1.3	Жуулчдын зорин очих газрын дэд бүтцийг	2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	820.0	Төр хурах-Цэцээ гүн хүртэлх явган	Шинээр 1 бүтээгдэхүүн	125.0	125.0	Жуулчдын зорин очих газрын дэд бүтцийг сайжруулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд	100

		сайжруулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ					аяллын чиглэлийг тохижуулсан.	нэмэгдүүлсэн байна.			Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг аялал жуулчлалын эргэлтэд оруулах зорилгоор Бэлхийн амны “Хүннүгийн язгууртны булш” цогцолборын тохижилтын ажил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Арван Долоо Гучин Долоо Энтертайнмент” ХХК-тай хамтран “Плэтайм” тогвортой ногоон хүрээлэн цогцолбор байгуулах төсөл, Улаанбаатар хот болон хот орчимд эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, зорилгоор “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх зэрэг 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүллээ.	
Зорилт 3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацийг нэвтрүүлж, гадаад дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.												
160	НЗДҮАХ 3.4.2.1.	Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад, дотоодод түгээн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ	2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	550.0	Аялал жуулчлалын 2 контент бэлтгэж, 20,000 хүн үзсэн	Аялал жуулчлалын 3 контент бэлтгэж, 50,000 хүн үзсэн байна.	-	-	Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүд “Улаанбаатар өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Талын салхи” олон улсын мото фестиваль “Дээлтэй монгол” наадам, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фүүд фестиваль” зэрэг арга хэмжээнүүдтэй холбоотой 42 контент хийж байгууллагын цахим хуудас <a href="http://www.tourism.ub.gov.mn">www.tourism.ub.gov.mn</a> болон <a href="http://www.visitulaanbaatar.net">www.visitulaanbaatar.net</a> газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд байршуулж 2,734,679 хүнд хүргэсэн.	100

161	НЗДҮАХ 3.4.2.2.	Улаанбаатар хотыг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд оролцож, сурталчлан таниулна.	2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	1,395.0	Нийт 4 олон улсын чанартай үзэсгэлэн, арга хэмжээнд оролцсон.	Олон улсын чанартай 8 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцсон байна.	172.9	172.9	<p>“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, тур оператор компаниудтай хамтран олон улсын 10 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцсон. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ ХБНГУ-ын Берлин хотноо 2024 оны 03 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 58 дахь удаагийн “ITB BERLIN-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн,</li> <li>✓ Улаанбаатар хотноо 2024 оны 04 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “TOURISM WEEK” олон улсын аялал жуулчлалын чуулган,</li> <li>✓ БНСУ-ын Сөүл хотноо 2024 оны 05 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 39 дэх удаагийн “SEOUL INTERNATIONAL TRAVEL FAIR- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн,</li> <li>✓ Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд 2024 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатар травел экспо-2024” олон улсын</li> </ul>	100
-----	--------------------	---	------	------	------------------	---------	---	--	-------	-------	---	-----

											<p>аялал жуулчлалын үзэсгэлэн,</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тайвань улсад 2024 оны 07 дугаар сарын 04-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Эко аялал жуулчлал” олон улсын зөвлөгөөн,</li> <li>✓ Япон улсын Токио хотноо 2024 оны 09 сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “TRAVEL EXPO JAPAN-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн,</li> <li>✓ Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд 10 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “ITM-MONGOLIA-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож,</li> <li>✓ БНХАУ-ын Гуан-жоу, Хонконг, Бээжин хотуудад 2024 оны 04 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд “GO MONGOLIA-ROAD SHOW 2024” арга хэмжээг хамтран зохион байгууллаа.</li> </ul> <p>“SEOUL INTERNATIOAL TRAVEL FAIR- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улс “Шилдэг PR маркетингтай” оролцогчоор, “ITM Монголиа-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь “Шилдэг тохижилттой” оролцогчоор шалгарлаа.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Зорилт 3.4.3. Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.												
162	НЗДҮАХ 3.4.3.1.	Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ	2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	170.0	Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ 3 байна.	Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ 5-г зохион байгуулсан байна.	160.0	160.0	Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай “Оюутан цагдаа-сургалт”, “Оюутан цагдаа-2024” арга хэмжээ, Жуулчны нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, жуулчны аюулгүй байдлыг хангах, зорчих үйлчилгээг нэвтрүүлэх арга хэмжээ, “Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалт”, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг амралтын газар, жуулчны баазуудын үйл ажиллагаанд хийсэн стандартын үзлэг шалгалт зэрэг 5 арга хэмжээг зохион байгууллаа.	90
163	НЗДҮАХ 3.4.3.2.	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад тавигдах ерөнхий шаардлагад нэмэлт оруулах замаар и-баримтад бүрэн холбож, нийслэл хотын	2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	-	Нийслэл хотын албан татвараас 7,345.3 төгрөг төвлөрсөн.	Нийслэл хотын албан татвараас нийслэлийн төсөвт 10,000.0 төгрөг төвлөрсөн байна.	-	-	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-ын хүрээнд “Онлайн бизнес төв” нэгдсэн системд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудын бүртгэлийг нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Нийслэл хотын албан татварт 26,506.5 (хорин зургаан тэрбум таван зуун зургаан сая таван зуун мянга) төгрөгийн татварын орлого төвлөрсөн байна.	100

		албан татвараас төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ										
164	НЗДҮАХ 3.4.3	Салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулна	2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	-	Хөтөч тайлбарлагч оюутан цагдаа зэрэг сургалтад нийт 619 хүнийг хамруулсан сургалт зохион байгуулсан.	Сургалтад 450 хүн хамруулсан байна.	295.1	295.1	Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Гастро аялал-2024” олон улсын хоолны тогооч бэлтгэх сургалт, “Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалт”, “Чингис хаан Үндэсний музейд тайлбар хийх эрх олгох” сургалт, “Олон улсын эксперт багштай зочлох үйлчилгээний сургалт”, “Оюутан цагдаа-2024 үйл ажиллагааны сургалт”, “Олон улсын хоолны жор технологи” сургалт зэрэг гадаад, дотоодын 6 төрлийн 18 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 865 хүнийг хамруулав.	100
Зорилт 3.4.4. “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлнэ.												
165	НЗДҮАХ 3.4.4.1.	“Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж хэрэгжүүлнэ	2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	-	Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлого шаардлагатай	“Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ” хэрэгжүүлнэ.	-	-	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/599 дүгээр захирамжаар батлуулсан Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг хэрэгжүүлэх 7 зорилтын 77 арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.	90
Зорилт 3.4.5. Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.												



166	НЗДҮАХ 3.4.5.1.	Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ	2024	НАЖГ	Нийслэлийн төсөв	-	Цар тахлын дараа Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц төлөвлөгөө шаардлагатай	Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	-	-	Ковидын дараах нийслэлийн Аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний 5 зорилтын 27 арга хэмжээний биелэлт 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.	90
НИЙТ ДҮН									2,061.1	2,000,0		97,2

ТАНИЛЦСАН  
ДАРГА



Д. БАТСҮХ

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА,  
ДАРГА

САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
Д. ГАНБОЛД

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:  
БОДЛОГЫН БАРИМТ ВИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН О.НЯМБАТ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
СУРГАЛТ, СУДАЛГАА, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН Ч. ДАХ-ОТГОМЧ.ЭНХ-ОТГОН